

“ДОРНОД СИБИРЬ-НОМХОН ДАЛАЙ” ГАЗРЫН ТОС ДАМЖУУЛАХ ХООЛОЙ

*Ж.Орхон**

“Дорнод Сибирь-Номхон далай” төслийн тухай

Дорнодын хоолой нь (“Дорнод Сибирь-Номхон далай” газрын тос дамжуулах хоолой) Өрнөд болон Дорнод Сибирийн газрын тосны ордуудыг Приморскийн хязгаарын боомтуудтай холбон улмаар Хятад, АНУ, Ази-Номхон далайн бүс нутгийн зах зээлд экспортод гаргахад ихээхэн үүрэг гүйцэтгэх стратегийн ач холбогдолтой хоолой юм. Түүний хүчин чадал жилд 80 сая тонн, нийт урт нь 4188 км байхаар төлөвлөсөн байна. Уг төсөл ОХУ-ын Засгийн Газрын 2004 оны 12 дугаар сарын 31-ний №1737-р Тогтоолын дагуу хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2005 оны 4 дүгээр сарын 26-ны Аж үйлдвэр эрчим хүчний Яамны тушаалын дагуу Дорнодын хоолойг барих үе шатлал батлагдсан байна. Эхний ээлжийн анхны чиглэл Тайшет (Эрхүү муж)- Усть-Кут (Эрхүү муж)- Казачинск (Эрхүү муж)- Тында (Амур муж)- Сковородино (Амур муж) чиглэлээр баригдаж жилд 30 сая тонн хүчин чадалтай байхаар төлөвлөж байсан ч Ерөнхийлөгч В.В.Путины захирамжаар Байгаль нуурын экологийн аюулгүй байдлыг хангах үүднээс ВСТО-1-н чиглэлийг хойд зүг рүү шилжүүлсэн байна.

Газрын тосны экспортын хоолой барих санааг анх “Юкос” компанийн удирдлагууд дэвшүүлж байсан ба зөвхөн Хятад руу гаргахаар төлөвлөж байжээ. 1999 оны 12 дугаар сард Юкосын эзэн Михаил Ходорковский Хятадын Үндэсний газрын тосны компанитай (CNPC) ОХУ-аас Хятад руу газрын тосны хоолой барих талаар хэлэлцээр хийж байжээ. 2001 оны 7 дугаар сарын 17-нд ОХУ-ын Ерөнхий сайд Михаил Касьянов болон БНХАУ-ын дарга Цзян Цзэминь нар “Орос-Хятадын чиглэл бүхий газрын тос дамжуулах хоолой барих үндсэн зарчим” (Ангарск-Дацин) хэлэлцээрт гарын үсэг зурсан байна. Уг төсөл 4 тэрбум долларын өртөгтэй хийгээд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг илүү татан оролцуулахаар төлөвлөж байсан ажээ. Гэвч улсаас дэмжлэг авч чадаагүйн дээр улсын гэсэн тодотголтой төсөл батлагдаж “Транснефть” компани гүйцэтгэхээр болсноор 2003 оны 5 дугаар сард уг хоёр төслийг “Дорнод Сибирь-Номхон Далай” гэсэн нэрэн дор нэгтгэж үндсэн чиглэлийг Ангарскаас Находк руу тэндээс Дацин руу (Хятад руу татах хоолойн урт 67 км хүчин чадал жилд 15 сая тонн) салаалуулж тавихаар болсон ч 2004 онд “Транснефть” компани Ангарскийг Тайшет, эцсийн зогсоол Находкийг Козьмино тохой болгон өөрчилсөн.


Одоогоор хоолойг 2 үе шаттай барихаар төлөвлөсний дагуу эхний ээлжинд Тайшет (Эрхүү муж)- Усть-Кут (Эрхүү муж)- Ленск (Якут)- Алдан (Якут)- Сковородино (Амур муж) эцсийн цэг- тусгай усан зогсоол “Козьмино” (Приморск хязгаар) хүртэл барьж, Номхон далайн эрэг дээр газрын тос хадгалах терминалыг зэрэг зэрэг барих бөгөөд үүнд нийт 18,1 тэрбум ам.доллар зарцуулж нийт урт нь 2694 км жилд 30 сая тонн хүчин чадалтай

* Ж.Орхон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

байхаар төлөвлөсөн. Хоолой Эрхүү мужийн нутаг дэвсгэрээр 984 км, Якугаар 1458 км, Амур мужаар 252 км тус тус үргэлжилнэ. Сковородино боомтоос газрын тосоо төмөр замаар Номхон далай руу тээвэрлэж жилд 15 сая тонн газрын тос дамжуулан тээвэрлэнэ. Мөн Сковородиногоос Хятад руу салаа замаар 15 сая тонныг тээвэрлэнэ. ВСТО-1 төслийн хүрээнд нийт газрын тос шахах 7 станц барьж, хөрөнгө оруулалтын хэмжээ 360 тэрбум рубль, мөн 60 тэрбум рубль Козьмино боомтыг барихад төлөвлөсөн байна.

Төслийн хоёр дахь шатанд (2010 оноос эхэлнэ) Сковородино-Козьминогийн чиглэлийн хоолойг барьснаар усан терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэхээр болсон байна. Ингэснээр ДСНД (ВСТО) хоолойг 2014 онд барьж дуусгах юм.

Дорнод Сибирь-Номхон Далай /ВСТО/ газрын тос дамжуулах хоолойн чиглэл



Эх сурвалж: www.comnews.ru/index/

Уг хоолойгоор дэлхийн зах зээлд гаргах газрын тосыг ВСТО гэж нэрлэх болсон ба энэ нь Европ руу гаргадаг Urals сортоос чанарын хувьд сайн гул илүү үнээр зарах боломжтой юм. Иймээс ОХУ уг хоолойг ашиглалтад оруулснаар газрын тосны экспортоос олж буй ашиг орлого үлэмж хэмжээгээр нэмэгдэнэ хэмээн үзэж байна. Одоогоор ОХУ олборлож буй нүүрс устөрөгчөө дотоодын болон Европын зах зээлд нийлүүлдэг, гэвч Европ энэхүү хараат байдлаас аль болох гарч, газрын тос хийг нөхөн сэргээгдэх эрчим хүчээр солих арга зам идэвхитэй эрэлхийлж байгаа нөхцөлд ОХУ-ын хувьд борлуулалтын өөр суваг олох нь чухал билээ. Иймд түлшний дутагдалд удаан хугацаанд орох Азийн эрчимтэй хөгжиж буй эдийн засаг энэ суваг мөн гэдэг нь тодорхой болсон энэ цагт уг төслийн макроэдийн засгийн үр ашиг ямар хэмжээнд хүрэх нь ойлгомжтой.

**“Дорнод Сибирь-Номхон далай” хоолой ба
БНХАУ-ын оролцоо**

БНХАУ эрчим хүчний аюулгүй байдлаа хангахын тулд одоогийн хэрэгцээгээ хангаад зогсохгүй ханган нийлүүлэлтийн эх үүсвэрийн диверсификацид ихээхэн анхаарал хандуулж байгаа билээ. Одоогийн байдлаар Иран болон Персийн булангийн орнууд болох Саудын Араб, Оман зэрэг улсууд үндсэн нийлүүлэгч бөгөөд тэдгээрт экспортын ихэнхи хувь ноогддог байна. Үндсэндээ Ойрхи Дорнодоос импортолж буй газрын тосны ихэнхи хувийг Индонез Малайзийг заагладаг Малаккскийн тохойгоор тээвэрлэдэг ба ОХУ-д 1,8% ноогддог. 2006 оны дунд үеэс Хятад Казахстанас түүхий эд авч эхэлсэн бол 2008 он гэхэд үүнд дээр нэмээд оросын газрын тосны экспортын 5 сая тонн нэмэгджээ. Гэвч дотоодын хэрэгцээг хангахад Атасу (Казахстан)-Аланшанькоу (Хятад) хоолойн хүчин чадал хангалтгүй байгаа тул Дорнод Сибирийн байгалийн баялагт анхаарал хандуулах нь аргагүй юм. ДСНД төсөл батлагдсан цагаас эхлэн ОХУ-ын түүхий эдийн ойрын хэрэглэгч болох Хятад, Японы хооронд өөр өөртөө ашигтай чиглэл лоббидох ширүүн тэмцэл өрнөж эхэлсэн. Уг төсөл Хятад, Япон, Өмнөд Солонгос болон Азийн бусад орнуудын хөрөнгө оруулалтыг Алс Дорнодын хөгжилд татан оруулахад ихээхэн ач холбогдолтой.

Орос, Хятадын хооронд арваад жил эрчим хүчний салбарт хамтран ажиллах талаар яриа хэлэлцээр явагдаж ихээхэн саад бэрхшээл туулсны эцэст 2008 оны 9 дүгээр сард болсон хоёр орны тэргүүн нарын 13-р уулзалтын үр дүнд 2009 оны 2 дугаар сард хоолой барих, түүхий газрын тос зарах худалдан авах, хоёр орны компаниудын хооронд зээл олгох гэх мэт олон асуудлыг шийдсэн хэд хэдэн хэлэлцээрт гарын үсэг зурсан. Эдгээрийг баталгаажуулахаар мөн оны 4 дүгээр сарын 21-нд Бээжин хотноо ОХУ-ын Засгийн газрын дэд сайд Игорь Сечин болон БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн орлогч дарга Ван Цишань нар гарын үсэг зурснаар газрын тосны салбарт 2011-2030 он хүртэл хамтран ажиллаж “Роснефть” компани жилд 15 сая тонн газрын тос нийлүүхээр болов. Үүний хариуд Хятадын тал оросын компаниудад 25 тэрбум ам.долларын зээл олгох болсноос 15 тэрбумыг “Роснефть”, 10 тэрбумыг “Транснефть” компаниудад тус тус олгохоор тохиролцсон байна.¹

Хятадын Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэнгийн ахлах шинжээч Ван Лицзюгийн үзэж буйгаар энэхүү Хэлэлцээр хоёр талд харилцан ашигтай хэмээжээ, тухайлбал, нэг талаас, дэлхийн эрчим хүчний зах зээлд үнийн уналтаас үүдэн хүнд байдалд орсон Оросын эрчим хүчний компаниудад дэмжлэг болж хүндрэлээс гарах гарц болох, нөгөө талаас Хятадын эрчим хүчний импортын диверсификацид чухал алхам болох явдал юм.²

“Дорнод Сибирь-Номхон далай” хоолойн бүдүүвч зураг



“Сковородино-БНХАУ-ын хил” шугамын нийт урт ойролцоогоор 65 км үргэлжилж Амур голын дундуур хиллэнэ. Түүнчлэн 2010 оны сүүлээр уг хоолойг барьж дуусгаснаар орос-хятадын компаниудын харилцан тохиролцсоны үндсэн дээр 2011 оны 1 дүгээр сараас эхлэн газрын тосны ханган нийлүүлэлт эхлэх ёстой. Дэд сайд Игорь Сечины үзэж буйгаар энэхүү “Сковородино-БНХАУ хил” салаа хоолойг барих явдал хоёр орны хоорондох харилцаанд түүхэн үүрэг гүйцэтгээд зогсохгүй хууль эрх зүйн үндэслэлтэй эрчим хүчний салбарын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэхэд чухал байр суурь эзлэх юм.³ Оросын эдийн засгийн амжилттай өсөх үндэс болсон нүүрс устөрөгчийн экспортын урсгалын диверсификаци аажимдаа бодит зүйл болох нь уг хамтын ажиллагааны гол үр дүн мөн.

Үүнээс гадна Засгийн газрын хоорондын гэрээ хэлэлцээрийн дагуу ОХУ-ын Внешэкономбанк болон БНХАУ-ын Хөгжлийн Улсын банкуудын хооронд орос-хятадын хамтарсан төслүүдэд хөрөнгө оруулах талаар гэрээ байгуулсан. Мөн Газпромбанк болон Хятадын экспорт-импорт банк, “Росатом” болон Хятадын цөмийн эрчим хүчний үйлдвэрийн улсын корпораци, Оросын нанотехнологийн улсын корпораци болон Хятадын шинжлэх ухаан техникийн яам, “Российские вертолёты” компани болон хятадын нисдэг тэрэгний компани зэрэг газруудын хооронд олон гэрээ байгуулагдсан байна.⁴

Шат дараалан хоолойг өргөжүүлснээр ОХУ 2020 он гэхэд Ази-Номхон далайн бүс нутгийн орнуудын газрын тосны нийт балансын 7% хувь эзэлж, Хятад-Япон-Өмнөд Солонгос гурван орны хувьд 10% эзлэх болно.

**Ази-Номхон далайн орнуудын зах зээлд Оросын
газрын тосны эзлэх хувийн прогноз**

	2008	ДСНД-1	ДСНД-2	ДСНД (80)
АНД зах зээлд эзлэх ОХУ хувь	2,7%	3,8%	5,5%	7,3%
Япон, Хятад, Өмнөд Солонгосын хувьд	4,3%	6,0%	7,5%	9,7%

Эх сурвалж: www.vstoneft.ru

Төслийн хэрэгжилт

2009 оны 12 дугаар сарын 28-нд ерөнхий сайд В.В.Путин Дорнод Сибирь, Номхон далайн газрын тос дамжуулах хоолойг (ДСНД) ашиглалтад оруулснаар ОХУ Ази, Номхон далайн эрчим хүчний зах зээлд өөрийн байр суурийг бэхжүүлэх чухал алхамыг эхэлсэн. Тухайлбал Козьмино дахь тэнгисийн газрын тос юүлэх тусгай зориулалтын боомт нээгдснээр ДСНД төслийн албан ёсны үйл ажиллагаа эхэлсэн байна. ДСНД хоолойн систем нь Оросын газрын тосны нийлүүлэлтийн чиглэлийг өргөтгөхөд зориулагдсан бөгөөд АНД-н ирээдүйтэй шинэ зах зээлийг оросын газрын тосоор хангах үүрэг гүйцэтгэх юм. Энэ систем нь одоо ажиллаж байгаа “Транснефть” хийн хоолойн гол шугамтай технологийн холболтод орж, Оросын нутаг дэвсгэр дэх баруун, зүүн чиглэлийн газрын тосны урсгалыг түргэн хуваарилах нөхцлийг бий болгож, нэгдсэн сүлжээ байгуулах боломжийг бүрдүүлж өгсөн. ДСНД хоолой нь Транс-Аляскийн хоолойгоос 3 дахин урт, дэлхийн хамгийн урт дамжуулах хоолой болно. ДСНД хоолойн гол нөөц бааз нь Баруун Сибирийн Томск муж, Ханты-Мансийск өөртөө засах тойрог юм. Энэ газрын тосны нөөц нь Зүүн Сибирь, Алс Дорнодын хэрэгцээг хангаад зогсохгүй, АНД-н орнуудад асар их хэмжээний нүүрс ус төрөгчийн түүхий эд нийлүүлэх боломжийг нээж өгч байна. Оросын эрчим хүчний стратегид Зүүн Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн түлш эрчим хүчний цогцолборыг хөгжүүлэх нь улс орны тэргүүлэх зорилт гэж заасан билээ. ОХУ-ын түлш, эрчим хүчний нөөцийн ихэнх хэсэг нь Зүүн Сибирь, Алс Дорнодод байдаг. Нөгөө талаас манай орны энэ хэсэгтэй АНД-н орнууд тэр дундаа үсрэнгүй хөгжиж байгаа эдийн засагтай, маш их түлш эрчим хүчний хэрэглээтэй Зүүн хойд Ази хил залгаа оршиж байна. Шинжээчдийн таамаглаж байгаагаар АНД-н тэргүүлэгч орнуудын газрын тосны хэрэглээ 2025 он хүртэл, дэлхийн хэрэглээнээс 25 хувиар давж, үүнд одоогийнхоос 3 дахин их болох Хятадын газрын тосны хэрэглээ ихэнх хувийг эзлэх юм байна.

ДСНД төслийн тээврийн хүчин чадлыг шаталсан хэлбэрээр жилд 15-30-50-80 сая тонноор нэмэгдүүлнэ. Үүний тулд ДСНД-1 хоолой, Хятад руу салаа хоолой барьж (Сковородино-Мохэ-Дацин), ДСНД-2-г барьж эцэст нь хоолойн хүчин чадлыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэх юм. Гэхдээ жилд 30 сая тонн газрын тос гаргахад дорнод сибирийн нөөц тийм ч хангалтгүй учраас цаашид өрнөд сибирийн орд газрууд ч эргэлтэд орох магадлалтай. Одоогоор 2010 онд 15 сая тонн тээвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд үүнийг Ванкор, Талакан, Верхняя Чонагийн орд газрууд хангана.⁵

Уг хоолой бүрэн ашиглатанд орсон хойно 80 сая тонн газрын тосны хуваарилалт хэрхэн явагдах тухайл: 15 сая тонн нь шууд Хятад руу татсан хоолойгоор, 15 сая тонн Хабаровск болон Комсомольск-на Амуре дахь газрын тос боловсруулах үйлдвэрт, 30 сая тонн нь “Козымино” боомтоор экспортод гарах юм. Ойрын ирээдүйд оросын газрын тосны борлуулалт ихсэх магадлал тун өндөр байгаа. Гэхдээ энэ төсөл удаан хугацааных бөгөөд борлуулалт цаашид өссөнөөр ихээхэн ач холбогдолтой. Зарим нэг хэрэглэгчдийн, тухайлбал Өмнөд Солонгос, Япон зэрэг орны, газрын тосны хэрэглээ 2015 он гэхэд дээд түвшинд хүрнэ. Үүнийг доорх хүснэгтээс харж болно:

Оросын газрын тосны 2020 он хүртлэх эрэлт хэрэгцээ ба 2030 оны харьцангуй үнэлэлт, мянган баррель/өдөрт

	2008	2015	2020	2020 2008 онтой харьцуулахад, %%	2020 2015 онтой харьцуулахад, %%	2030
Хятад	7850	10300	11700	49%	14%	12060
Япон	4785	5160	4940	3%	-4%	4560
Өмнөд Солонгос	2175	2360	2260	4%	-4%	2040

Ийнхүү зарим судлаач, мэргэжилтнүүд, тухайлбал улс төр, эдийн засгийн мэдээллийн Агентлагийн ерөнхий захирал Дмитрий Орловын үзэж буйгаар “Дорнодын хоолой” ОХУ-д сонголт хийх эрх чөлөө олгож буй гэжээ. Нүүрс устөрөгч тээвэрлэх сонголтын эрх чөлөө гэдэг нь Оросын тусгаар тогтнол, үндэсний эрчим хүчний аюулгүй байдлын баталгаа болж өгөх бөгөөд Европын зах зээлд Орос орон идэвхитэй тоглогч бол Ази-Номхон далайн зах зээлд сүүлийн үеэс эхлэн байр сууриа олохоор зэхэж байгаа билээ. Энэ зорилтыг ДСНД хоолой шийдэх учиртай. Оросын улс төрийн намуудын удирдлагын хүсэл эрмэлзлэл, Хятадтай явуулах стратегийн түншлэл болон “Транснефтийн” техник, технологи, зохион байгуулалтын зорилтууд- энэ бүх хүчин зүйлсийн хослол энэхүү агуу төслийн эхний шатыг бодитоор биелүүлэхэд нөлөөлсөн хэмээн тэрээр үзэж байна.

Мөн Advanced Research-ийн шинжээч Михаил Бакулевын үзэж байгаагаар Оросын засгийн газрын явуулж байгаа газрын тосны экспортны диверсификаци “Оросын газрын тосны салбарын хөгжилд явагдах зайлшгүй алхам” гэжээ. Түүнчлэн судалгааны дүнгээр, Европ бус харин Ази-Номхон далайн орнуудад газрын тосны эрэлт хэрэгцээ үлэмж нэмэгдэх тул энэ чиглэлийг хөгжүүлэх нь хамгийн зөв шийдэл юм. Ингэснээр уг бүс нутгийн түүхий эдийн суурь хөгжих боломжтой бөгөөд бүхэлдээ Дорнод Сибирь Алс Дорнодын хязгаар нутгийн эдийн засгийн хөгжилд ихээхэн түлхэц өгч Оросын хөгжлийн ирээдүйд шинэ хөшүүрэг болох нь дамжиггүй.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Китай поможет “Роснефти” с долгами. “Коммерсант”, №197 от 2.10.2008
2. В энергетическом сотрудничестве между КНР и РФ наступил долгожданный прорыв. Агентство Синьхуа, 22/04/2009.
3. Алёна Корпусова. “Китайский фактор”, портал “Восточный нефтепровод”. 14.07.2009
4. Online. Россия и Китай подписали соглашение о сотрудничестве в нефтяной сфере. 28.10.2001
5. Д.Александров. ВСТО и российская нефть в АТР. www.vstoneft.ru